



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/66/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: О.Алтансүх Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Менежментийн захидал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

*005002.27* № *1/123*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ 7

БАЯНХОНГОР СУМЫН  
БАЯН-ОЙТ БАГА СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.АЮУРЗАНА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

00500122


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Аюурзана танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-наас 2020.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд эерэг зан чанар, зөв хандлагыг төлөвшүүлэн, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг Ерөнхий эрдмийн бага боловсрол олгох гэж тодорхойлжээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS болон цалингийн Payroll программ” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 664928,2 мянган төгрөгөөс тооцон 13298,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2025130,7 мянган төгрөгөөр буюу 9,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	59,3	59,3	0
Бараа материал	58,257,5	90,139,0	31,881,5
Үндсэн хөрөнгө	227,545,3	2,234,201,0	2006655,7
Хуримтлагдсан элэгдэл	-25,722,9	-13,406,4	-12,316,4
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>163,289,2</u></b>	<b><u>2,188,420,0</u></b>	2,025,130,7
Өр төлбөр	<b><u>00.00</u></b>	<b><u>3,830,4</u></b>	3,830,4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	163,289,2	2,184,589,5	2,021,300,3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>163,289,2</u></b>	<b><u>2,188,420,0</u></b>	2,025,130,7

Бараа материалын дансны үлдэгдэл 31881,5 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний болон аж ахуй, эм боох бараа материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2006655,7 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 03-дугаар сарын 19 ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2700.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оын 12-дугаар сарын 25 ны өдрийн 122 дугаар тогтоолоор 1973538.2 мянган төгрөгийн 250 хүүхдийн цогцолбор барилга орлогод авснаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан элэгдэл 13406,5 мянган төгрөгөөр тайланд оны элэгдлийн зардлаар нэмэгдэж 135979,5 мянган төгрөг болсон байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 319,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2184589,5 мянган төгрөг болж өмнөх оноос 2,021,300,3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,021,300,3 мянган төгрөгөөр өссөн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70101 кодтой нэг хөтөлбөрт зориулан 709990,3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 569986,9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 140003,4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 709990,3 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь улсын төсвөөс 569986,9 мянга, орон нутгийн төсвөөс 140003,4 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 2263,2 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14,3 сая төгрөгийн 1 алдаа, зөрчил илэрч алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### Илрүүлэлт:

Тайланд онд 3599,1 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй бөгөөд үлдэгдлийг түүвэрлэж тулгахад мах, сүү, үзэм зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг төсөвтэй харьцуулахад их хэмжээгээр авч хүнсний нөөцийг бэлдсэн байгаа нь хадгалалтын хугацаа

алдагдах, чанар байдал өөрчлөлт орох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлтэй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

**Илрүүлэлт:**

Баян-ойт бага сургууль нь ажиллагсдад улирал бүр үр дүнгийн урамшууллыг тооцож олгосон атлаа 2019 оны 12 дугаар сард сургуулийн захирлын А/40-тоот тушаалаар нийт 51 багш, ажилчдад жилийн ажлын үр дүнгээр 10888,9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хууль зөрчин давхардуулан олгосон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 134 мэдээллийг, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	10	1		
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	80	16		
	Нийт	27	151	134	17		

2019 оны тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний 10 сарын мэдээ, бүтэн жилээр тавих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 1-9-р саруудын мэдээнүүд, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэг хаяг мэдээний 3-р сарын мэдээ, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээний 2, 5, 8, 9, 12-р сарын мэдээг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэнтэй холбоотой байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,316,957.40</b>	<b>90,198,488.70</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	59,391.00	59,391.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	59,391.00	59,391.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	59,391.00	59,391.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,257,566.40	90,139,097.70
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	155,350.00	3,987,631.00
35130	Эм боох материал	155,350.00	3,987,631.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	58,102,216.40	86,151,466.70
35410	Бичиг хэргийн материал	3,799,502.51	3,341,202.51
35420	Аж ахуйн материал	10,858,649.13	18,550,959.13
35440	Түлш, шатах тослох материал	1,100,586.92	1,100,587.22
35450	Барилгын засварын материал	2,657,850.00	5,523,005.00
35460	Хүнсний материал	1,099,085.01	3,599,170.01
35470	Бусад хангамжийн материал	38,586,542.83	54,036,542.83
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>104,972,311.65</b>	<b>2,098,221,552.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	104,972,311.65	2,098,221,552.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	104,733,061.61	2,098,062,052.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	70,677,232.00	2,044,215,473.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,874,659.57	-3,052,613.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,724,845.19	83,814,145.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,546,961.08	-66,214,502.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,723,493.63	93,123,493.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,949,070.76	-66,416,325.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	294,000.00	294,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-122,600.35	-136,600.39
39217	Ном	8,806,782.55	12,434,982.55
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	239,250.04	159,500.08
39301	Програм хангамж	319,000.00	319,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-79,749.96	-159,499.92
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>163,289,269.05</b>	<b>2,188,420,041.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>3,830,455.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	3,830,455.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	3,830,455.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,593,708.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	2,236,747.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,236,747.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>163,289,269.05</b>	<b>2,184,589,586.47</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	163,289,269.05	2,184,589,586.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,225,483.90	52,225,483.90
51101	Өмч: - төрийн	52,225,483.90	52,225,483.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	26,927,111.15	2,048,227,428.57
51210	Өмнөх үеийн үр дүн	26,927,111.15	26,927,111.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,021,300,317.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,136,674.00	84,136,674.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>163,289,269.05</b>	<b>2,188,420,041.47</b>

### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>483,315,381.00</b>	<b>2,686,228,541.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,976,238,241.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>1,976,238,241.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,976,238,241.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,976,238,241.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>15,092,281.00</b>	<b>140,003,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	468,223,100.00	569,986,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>140,003,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	140,003,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>499,595,939.86</b>	<b>664,928,223.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>499,595,939.86</b>	<b>664,928,223.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>419,066,677.39</b>	<b>612,317,890.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>295,276,852.00</b>	<b>398,691,934.00</b>
210101	Үндсэн цалин	295,276,852.00	398,691,934.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,601,823.53</b>	<b>50,021,731.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,601,823.53	50,021,731.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,994,745.00</b>	<b>128,814,908.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,275,277.00	9,353,532.00
210302	Түлш, халаалт	30,516,740.00	112,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,717,255.00	7,461,376.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,446,270.89</b>	<b>11,560,510.20</b>
210401	Бичиг хэрэг	1,361,300.00	2,999,150.00
210402	Тээвэр, шатахуун	719,698.89	2,579,999.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	487,762.00	1,014,520.50
210404	Ном, хэвлэл	00.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	877,510.00	4,786,840.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,750.00</b>	<b>80,896.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,750.00	80,896.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>569,950.00</b>	<b>5,414,545.00</b>
210604	Урсгал засвар	569,950.00	5,414,545.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>523,000.00</b>	<b>1,002,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	523,000.00	1,002,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>455,600.00</b>	<b>766,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	455,600.00	766,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,162,685.97</b>	<b>15,964,465.88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,221,700.00	483,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,218,000.00	2,074,966.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,722,985.97	13,406,499.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,529,262.47</b>	<b>52,610,333.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>79,100,936.00</b>	<b>50,347,065.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	300,000.00

**Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,187,405.00	46,187,065.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,450.00	3,860,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,428,326.47</b>	<b>565,068.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,428,326.47	565,068.50
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,698,200.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,698,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-16,280,558.86</b>	<b>2,021,300,317.42</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-36,611,341.45</b>	<b>2,021,300,317.42</b>

**3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>483,315,381.00</b>	<b>709,990,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>483,315,381.00</b>	<b>709,990,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	468,223,100.00	569,986,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>140,003,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	140,003,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>483,315,381.00</b>	<b>709,990,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>483,315,381.00</b>	<b>709,990,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>403,582,023.53</b>	<b>655,066,981.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>295,437,700.00</b>	<b>394,438,418.00</b>
210101	Үндсэн цалин	243,880,700.00	312,444,000.00
210102	Нэмэгдэл	33,125,900.00	37,020,300.00
210104	Урамшуулал	18,431,100.00	44,974,118.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,540,366.53</b>	<b>52,038,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,531,900.00	37,631,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,937,400.00	3,601,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,346,500.00	2,881,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	567,600.00	720,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,156,966.53	7,203,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,994,745.00</b>	<b>127,221,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,275,277.00	9,353,532.00
210302	Түлш, халаалт	30,516,740.00	110,406,292.00
210303	Цэвэр, бохир ус	7,717,255.00	7,461,376.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,990,762.00</b>	<b>14,003,420.50</b>
210401	Бичиг хэрэг	482,500.00	2,239,850.00
210402	Тээвэр, шатахуун	602,500.00	2,580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	487,762.00	1,014,520.50
210404	Ном, хэвлэл	68,000.00	2,271,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,350,000.00	5,762,850.00

**Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	124,000.00	8,655,177.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,500.00	2,605,177.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,500.00	6,050,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,170,450.00	41,942,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	20,882,000.00
210602	Тавилга	00.00	9,800,000.00
210604	Урсгал засвар	3,170,450.00	11,260,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	523,000.00	1,002,400.00
210702	Дотоод албан томилолт	523,000.00	1,002,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	455,600.00	728,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	455,600.00	478,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,345,400.00	15,037,366.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,845,400.00	7,786,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	7,250,566.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>79,733,357.47</b>	<b>54,923,318.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>78,305,031.00</b>	<b>52,660,050.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,391,500.00	48,800,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,450.00	3,860,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	1,698,200.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,698,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	565,068.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	565,068.50

**3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн /төгрөг/
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,771,797.23	-2,771,797.23
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	26,927,111.15	163,289,269.05
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	26,927,111.15	163,289,269.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	26,927,111.15	163,289,269.05
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,021,300,317.42	2,021,300,317.42
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,048,227,428.57	2,184,589,586.47

### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан


Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	709,990,300.00	707,727,031.50
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	709,990,300.00	707,727,031.50
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	657,096,700.00	655,066,981.50
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	394,502,800.00	394,438,418.00
210101	Үндсэн цалин	312,444,000.00	312,444,000.00
210102	Нэмэгдэл	37,020,300.00	37,020,300.00
210104	Урамшуулал	45,038,500.00	44,974,118.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,038,500.00	52,038,500.00
210201	Тэтгэврийн даатгал	37,631,900.00	37,631,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,601,600.00	3,601,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,881,300.00	2,881,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	720,300.00	720,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,203,400.00	7,203,400.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	128,862,300.00	127,221,200.00
210301	Гэрэл, цахилгаан	6,025,900.00	9,353,532.00
210302	Түлш, халаалт	115,356,400.00	110,406,292.00
210303	Цэвэр, бохир ус	7,480,000.00	7,461,376.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,358,400.00	14,003,420.50
210401	Бичиг хэрэг	1,719,800.00	2,239,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,580,000.00	2,580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,340,600.00	1,014,520.50
210404	Ном, хэвлэл	3,299,800.00	2,271,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	402,000.00	135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,016,200.00	5,762,850.00
2105	<b>Нормативт зардал</b>	8,669,500.00	8,655,177.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,603,400.00	2,605,177.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,066,100.00	6,050,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	42,050,600.00	41,942,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,909,500.00	20,882,000.00
210602	Тавилга	10,000,000.00	9,800,000.00
210604	Урсгал засвар	11,141,100.00	11,260,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,002,400.00	1,002,400.00
210702	Дотоод албан томилолт	1,002,400.00	1,002,400.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	583,600.00	728,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	333,600.00	478,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15028600.00	15037366.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,786,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,028,600.00	7,250,566.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	52893600.00	52660050.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	52,893,600.00	52,660,050.00

Баянхонгор сумын Баян-ойт бага сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,033,600.00	48,800,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,860,000.00	3,860,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>709,990,300.00</b>	<b>707,727,031.50</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>569,986,900.00</b>	<b>569,421,831.50</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	569,986,900.00	569,421,831.50
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>140,003,400.00</b>	<b>138,305,200.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	140,003,400.00	138,305,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	23.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	16.00

**Аудитын тайланг**

**Хянансан:**

Тэргүүлэх аудитор  Б.Мөнхбат 2018.02.25

Аудитын менежер  А.Цээням 2018.02.15

**Бэлтгэсэн:**

Аудитор  О.Алтансүх 2018.02.15

